



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 13 өдөр

Дугаар А/3117

Есөнбулаг

Дансны үлдэгдэл буцаан олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 243 дугаар тушаал, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2024 оны 14 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төрийн сангийн нэмэлт санхүүжилтийн татан төвлөрүүлэлтийн дансанд 2022 оны жилийн эцэст Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газрын нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн 9,945,909 (есөн сая есөн зуун дөчин таван мянга есөн зуун ес) төгрөгийг буцаан олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), төсвийн ерөнхий нягтлан бодогч (Д.Ундрахбаяр)-д тус тус зөвшөөрсүгэй.

2. Төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнахыг Есөнбулаг сумын Засаг даргын Тамгын газар (Ж.Батцэцэг)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

